

## **Edmonds Community College**

АНУ Вашингтон муж Сиатл хотоос ойр

### **Их сургуулийн эрдмийн зэрэгээ бидэнтэй эхэлнэ үү.**

Баклаврын зэрэгээ горилон их сургууль руу шилжихэд хялбар

Дотуур байр болон Айлд байрлах

### **Бидний байршил?**

Edmonds Community College нь Сиатл хотоос хойд зүгт 24 километрт орших нийтийн, 2 жилийн сургалттай коллеж юм. Манай коллеж нь Lynnwood хотод орших бөгөөд 50 акр талбайтай амар тайван газар оршдог. Дэлгүүр, банк, түрээсийн орон сууц, кафе мөн ресторонуудад ойрхон байршилтай.

### **Бидний орчин тойрон**

Edmonds Community College нь Сиатл хотын төвөөс 25 мин мөн Сиатл-Такома олон улсын нисэх онгоцны буудлаас 45 мин зайд оршдог. Түүнчлэн Канадын Ванкоүвер хотоос 1 цаг 30 мин зайд мөн далайн эргээс холгүйхэн оршино.

Бид аюулгүй, дуу чимээ бага, сурагчдын сурах нөхцөлийг бүрэн хангасан Сиатл хотын ойролцоо оршино. Манай сургууль нь мөн гольфын курс хичээллүүлдэг. Манай оюутны хотхон нь дэлгүүрүүд, банкууд, ресторонуудаас ердөө хэдхэн алхмын зайд оршдог.

Lynnwoodын онцлох газруудын нэг болох Alderwood mall нь дотроо кино театр, үндэсний голчлох дэлгүүрүүд мөн хооллох газруудыг багтааснаараа онцлогтой.

Ойролцоо орших Эдмондс нь Номхон Далайн эргийн дуу чимээ бага Puget Soundын эргээр оршдог. Үүний ойролцоо өргөн сонголт бүхий ресторонууд, дэлгүүрүүд, урлагийн галлерейнүүд мөн Olympic Peninsula-д байх Olympic үндэсийн парк руу явах усан онгоц байх болно.

Сиатл ойр орчим – БОИНГ компани, Microsoft корпораци, Starbucks кофе компани, Amazon.com Inc. – уудын өлгий нутаг юм. Мөн үндэсний хэмжээний том спортын багууд болох Mariners бейсболын баг, Sounders FC хөл бөмбөгийн баг, Seahawks америк хөл бөмбөгийн багуудын өлгий нутаг болно.

Сиатл нь технологи, урлаг, бизнес, соёлын шинэ соргог санаа гаргадгаараа алдаршсан хот юм. Нэртэй театрууд, опера, симфони, орчин үеийн концертууд, урлагийн үзэсгэлэнгүүд нь Сиатл хотын бэлэг тэмдэг боломж өгдөг юм. Мөн цанаар гулгах, snowboarding, hiking хийхэд тохиромжтой газрууд ойрхон. Ойр орчмын ресторонууд нь Европ болон Ази хоолнуудаараа алдартай.

### **Онцгой заавар зөвлөгөө**

Edmonds Community College ийн төлбөр нь ихэнх их сургуулиудаас 2 дахин бага үнэтэй. Манай сургуулийн 2 жилийн хугацаатай Associate зэрэг нь АНУ доторх ихэнх их сургуулиудын эхний 2 жилийн сургалттай тэнцнэ.

**Бидний оюутны хотхонд их сургууль. Их сургуулийн дадлага туршлагийг танд.**

Central Washington Их сургууль (CWU) нь Edmonds СС-ын орчинд байрлах бөгөөд баклаврын зэрэгийг санал болгож байна. Үүнд: Нягтлан бодох бүртгэл, Бизнесийн удирдлага, Мэдээлэл технологи, Удирдлагийн менежмент, Хууль зүй, Нийгмийн шинжлэх ухаан түүгээр зогсохгүй Нягтлан бодох бүртгэлээр магистрын зэрэг хамгаалах боломжтой.

Edmonds СС болон CWU ийн сурагчид нь адил байранд хичээллэж, номын сан, сургуулийн хоолны газар болон дотуур байранд (Rainier Place) хамтдаа цагийг өнгөрөөдөг.

**Их сургуулийн дадлага туршлагаа эндээс эхлэх.**

2 жил Edmonds Community College.д

+

2 жил АНУ-ын их дээд сургуульд

=

4 жилд баклаврын зэрэг

**Associate-ын зэрэг болон их сургууль руу шилжих процесс**

2 жилийн хугацаанд Associate of Arts, Associate of Sciences, Associate of Technical Arts зэргүүдийг санал болгож байна. Эдгээр зэргүүдийн аль нэгийг сурагчид дүүргэсний дараагаар 4 жилийн сургалттай их сургуульруу шилжин баклаврын зэрэгээ эзэмших боломжтой. Доорх дурдах курсүүд нь нилээд түгээмэл:

**Зэргүүд:**

**Associate of Arts:**

Нягтлан бодох бүртгэл, Бизнес, Антропологи (Хүн судлал), Архитектур, Урлаг, Мэдээлэл холбоо, Эдийн засаг, Боловсрол, Англи хэл, Франц хэл, Газар зүй, Герман хэл, Түүх, Олон улс судлал, Япон хэл, Сэтгүүл зүй, Дуу хөгжим, Философи (Гүн ухаан), Улс төр судлал, Сэтгэл зүй, Социологи, Испани хэл, Илтгэх урлаг, Театрын урлаг, Медиа...г.м.

**Associate of Science:**

Одон орон судлал, Биологи, Хими, Компютерын шинжлэх ухаан, Инженер, Байгаль орчин судлал, Геологи, Математик, Анагаах ухаан, Сувилах ухаан...гэх мэт.

**Associate of Technical Arts:**

Бизнес мэдээллийн технологи, Бизнес менежмент, Компютер анимейшн, Компютер мэдээллийн систем, Барилгын менежмент, Дижитал дуу хөгжим, Сургуулийн өмнөх насны боловсрол, Хоолбооны эрүүл мэнд, Цэцэрлэгжүүлэлт, Аялал жуулчлал, Түүхий эдийн шинжлэх ухаан, Веб загвар зохион бүтээл...гэх мэт.

**Их сургуулиуд**

Манай сурагчид эдгээр АНУ –н топ их сургуулиудруу шилжин суралцдаг.

University of Washington  
Washington State University  
Cornell University  
Purdue University  
Rutgers University  
University of California, Berkeley  
Michigan State University  
University of Indiana  
University of Southern California  
Georgia Institute of Technology  
Seattle University  
University of Virginia  
University of Texas  
University of Wisconsin  
University of Minnesota  
University of Kansas  
University of Buffalo, N.Y.  
State University of New York, Buffalo  
San Francisco State University  
Pennsylvania State University  
Ohio State University  
Central Washington University  
Болон бусад

### **Ахлах сургуулиас их сургууль руу**

Ахлах сургуулын дипломоо хамгаалахын сацуу коллежийн кредит ангиудаас сонгон элсэх орох боломжтой. Хэрэв сурагч 16 настай юм уу түүнээс дээш тохиолдолд бидний ахлах сургуулиас их сургууль хэмээх программд хамрагдаж болох юм.

Edmonds Community College нь 1993 оноос эхлэн олон улсын ахлах сургуулийн программыг хэрэгжүүлсэн бөгөөд 500 гаран сурагчид ахлах сургуулийн диплом болон Associate зэргийг хослуулан авчихаад байна. Бид энэхүү программаараа АНУ дотроо нилээд туршлагатайд тооцогддог.

Та цаг хугацаа болон мөнгөө хэмнэнэ!

$\frac{1}{2}$  жил ахлах сургуулийн ангиудад (энэ нь дундаж сурагчдын хугацаа, гэхдээ хэзээ энэ хөтөлбөрт хамрагдсанаас шалтгаална)

$\frac{1}{2}$  жил Associate зэргийн ангиудад

+

2 жил их дээд сургуульд

=

4 жилд Ахлах сургуулийн диплом, Associate зэрэг мөн Баклаврын зэрэг авах боломж

### **Мэргэжлийн зэргүүд болон ажлын туршлага**

Мэргэжлийн зэрэгээ 2 жилд эзэмшин авах/ эсвэл 6 хан сард сертификат авах. Associate зэрэг нь Баклаварын зэрэг горилон их сургууль руу шилжихэд хэрэглэгдэнэ эсвэл шууд ажлынхаа гарааг эхэлсэн ч болох юм.

### **Албан журмын бус практикын дадлага (OPT-Optional Practical Trainig)**

Зэрэг юмуу сертификатаа дүүргэсний дараа та АНУ-д мэргэжлийнхаа дагуу OPT эрхээ ашиглаад эх оронруугаа буцахаас нэг жилийн өмнө эсвэл их сургуульруу шилжихээс нэг жилийн өмнө ажиллах эрхтэй юм. Баклаврын зэрэгээ хамгаалсны дараа эх оронруугаа буцахаас өмнө мөн нэмэлт нэг жил мэргэжлийнхээ дагуу ажиллах эрхтэй.

1/2 жил ахлах сургуулийн ангиудад (дундаж сурагчдын хугацаа, гэхдээ хэзээ энэ хөтөлбөрт хамрагдсанаас шалтгаална)

1 юмуу 2 жил коллеж-д

+

1 жил ажиллах

+

2 жил Баклаврын зэрэг.т

+

1 жил ажиллах

=

4 өөс 6 жилийн дотор Сертификат, Associate зэрэг, Баклаврын зэрэг мөн хоёр жилийн ажлын дадлага туршлага

### **Гүнзгийрүүлсэн Англи хэл**

Англи хэлийг түргэн хугацаанд Гүнзгийрүүлсэн Англи хэл программд хамрагдан сурч болно. Бид энэхүү программаараа дамжуулан сурагчдыг коллеж болон их сургуулын ангиудад бэлтгэдэг. Үүнд:

Долоо хоног бүр 20 цагийн хичээл

Жижиг анги танхим

Анхан шатнаас гүнзгийрүүлсэн хүртэл 5 шатны ангитай

TOEFL-д бэлтгэх ангиуд

Нээлттэй элсэлт: куартэр эхэлснээс хойш 4 долоо хоногын дотор хэзээд ч элсэн орсон болно

Орчин үеийн мэдлэгийн эх үүсвэр: сурагчид зөвхөн багшаас суралцахаас гадна нэмэлт болгон компьютер интернет ашиглах

Америк сурагчидтай нүүр тулан харилцан ярилцах

Сурагчид өдөр бүр 4 ангийн хичээлд сууж, олон талын арга барилд суралцах болно:

Уншлага

Дүрэм

Бичлэгийн анги  
Яриа/ Сонсгол

Онцгой гүнзгийрүүлсэн ангиуд:  
Дуудлага/хэллэгийн анги  
Эрчимжүүлсэн яриа/сонсгол  
Их сургуульд бэлтгэх анги

### **Орон нутагт түнш болох**

Туршлагаа ахиулах. Орчин тойрны сургуулиуд болон үйлчилгээний газруудад сайн дурын ажил хийн дадлага туршлага солилцох.

### **Сурагчдад зориулсан үйлчилгээнүүд: Чиний амжилтын төлөө тусална!**

Олон улсын сурагчдын үйлчилгээний төв (ISS) нь туршлагатай зөвлөгчүүд болон олон хэлээр ярьж чаддаг ажилтнуудтай юм. Манай багш нар ч мөн үргэлж сурагчдын асуултад хариулахад бэлэн байдаг.

### **Зөвлөгөө болон Сурагчдын зүг чиг**

Зөвлөгчүүд нь сурагчдын онол эрдмийн тал дээр, визний асуултууд, хувийн болон соёлын ямар ч төрлийн асуултад хариулах болно. Квартер болгонд сургуультай танилцах долоо хоног зохион байгуулагддаг бөгөөд энэ үеэр шинэ сурагчид коллежийнхаа тухай илүү мэдээлэл олж аван, шинэ найзуудтай болон, Сиатл хотынхоо орчин тойронтой танилцах боломж олгож өгдөг юм.

### **Их сургуульруу шилжих төлөвлөгөө**

Манай их сургуулийн шилжилт хариуцсан зөвлөгч нь олон улсын оюутнуудад хэрхэн яаж зөв их сургуулиа олон, бүртгүүлэхэд тэр бүхий л процесст тусалдаг. Жил бүр манай олон оюутнууд дээд мэргэжлийн их сургуулиуд руу шилжин суралцдаг.

### **Үйл ажиллагаанууд болон сургуулийн оролцоо**

Оюутнууд сонирхол нэгтэй сурагчидтайгаа хамт клуб байгуулан мөн түүндээ элсэж болно. Манайд дуу хөгжмийн клубээс авхуулаад компьютер тоглоомын клуб гэх мэтчилэн олон төрлийн клубүүд байдаг. Оюутнууд оюутны зөвлөлд элсэн мөн кампус дотроо ажил хийн цалин авах боломжтой. Молл явж шоппинг хийн эсвэл Сиатл хотын төврүү явж ч болно. Англи хэлтэй найзуудтай болон амьдралынхаа туршийн найз нөхөдтэйгөө учирч болох юм. Сагсан бөмбөг тоглох, волейболл тоглох, хөл бөмбөг тоглон сургуулийн орчиндоо цагийг зугаатай өнгөрөөж болно. Бичих дуртай хүмүүс сурагчдын сонинд нийтлэлээ хэвлүүлсэн ч болно. Суралцагч грүпптэй нэгдэн хичээлээ хамт давтаж болно.

Коллежийн үйлчилгээнүүдэд ямар нэгэн атлетикт хамрагдах таатай нөхцөл, сурагчдын амралтын өрөө, тоглоомын өрөө, ресторанууд, кафенууд, номын сан, номын дэлгүүр, бэлэн мөнгөний машин мөн компьютер өрөөнүүд багтдаг. Сурагчид энэхүү орчинд шинэ найзуудтай болж хичээлээ давтан оюутны хотхондоо болон ойр орчиндоо зугаацаж өнгөрөөх боломжтой.

## **Тэтгэлэгүүд**

Намар, өвөл, хаварын квартеруудад шинээр болон суралцаж буй оюутнуудад тэтгэлэгт хамрагдах бүрэн боломжтой.

## **Орон сууц**

Дотуур байр

Рейниер Плес

Рейниер плес хэмээх шинэхэн баригдсан оюутны хотхонд байрлах дотуур байранд амьдрах боломжтой. Орон сууцаа Америк оюутнуудтай болон олон улсын оюутнуудтай хамтран эзэмших боломжтой. Энэхүү эд хогшиллууд нь хувийн өрөө болон угаалгын өрөөнүүдийг илтгэнэ. Ангиудруугаа минут алхаад л орно.

## **Голчлох зүйлүүд:**

Хувийн унтлагын өрөө

4 унтлагын өрөө/2 угаалгын өрөө, том өрөө болон гал тогоо

Ор, хичээлийн ширээ, бусад тавилгууд

Интернет, утас, телевизын холболт

Хувцас угаах газар

Нүүхэд хэрэгтэй хэрэгслүүд

## **Оюутны хотхонд байрлалтай Рейниер плес нь:**

Давхар болгонд дотуур байрны зөвлөгч нар амьдрах

Сурагчид иайзуудтайгаа уулзах боломжтой арга хэмжээнүүд зохиогдох

Нийт 181 өрөөтэй

## **Хөүмстей болон хаус хувааж хэрэглэх**

Америк айлууд сурагчдыг гэрийнхээ нэг гишүүнээ болгон хүлээн авахад бэлэн байдаг. 1980 оноос хойш олон улсын оюутнуудыг манай орчин тойрны айлууд хүлээж авсаар ирсэн билээ. Бид үргэлж сурагчдынхаа байгаа айлтай болон сурагчидтайгаа нягт холбоотой ажилладаг.

## **Хөүмстей**

Шинэ найзуудтай болох, Англи хэлээ дээшлүүлэх, Америк амьдралтай танилцах. Амьдрах айл тань Америк соёл болон амьдралд өөрийг тань танилцуулах болно.

## **Хаус хувааж хэрэглэх**

Өөрийнхөө сонголтоор биеэ даан нэгэн айлын өрөөг хөлслөн амьдарч бас болно. Хоолоо айлтайгаа болон ганцаарчлан хийн идэж болно.

## **Онгоцны тосож авах үйлчилгээ**

Рейниер плесийн ажилтнууд буюу дотуур байрны ажилтнууд шинээр ирж буй оюутнуудыг тосож авдаг. Мөн тэдгээр оюутнуудаа очих айлуудад нь байрлуулж өгдөг.

## **Автобусны үйлчилгээ**

Орон нутгийн автобус байнга танд үйлчлэх болно. Яг оюутны хотхон дотор мөн автобусны зогсоол байдаг.

### **Хэрхэн байранд бүртгүүлэх**

Онлайнаар бүртгүүлэх! Бүртгэлийн хуудсаа <http://international.edcc.edu> гэсэн хаягаар татаж авч болно.

Бүртгэлийн хуудсаа 425.774.0455 дургааруу факсдах

[Iss\\_desk@edcc.edu](mailto:Iss_desk@edcc.edu) гэсэн хаягруу и-мейлээр явуулах

Мөн доорх шуудангийн хаягаар материалаа илгээж болно.

International Student Services

Edmonds Community College

20000 68<sup>th</sup> Avenue West

Lynnwood, Washington 98036, U.S.A.

Манай коллежид элсэхэд TOEFL болон бусад төрлийн тестүүдийг өгсөн байх шаардлагагүй. Ирснийхээ дараа манай коллежийн Англи хэлний шалгалт өгөн коллежийн ангиуддаа орж болно. Хэрэв зайлшгүй тохиолдолд коллежийн бэлтгэл ангийн Англи хэлэнд орж болно.

TOEFLийн IBT 55, CBT 157, PBT 480 оноонуудтай эсвэл IELTS 5.0 буюу түүнээс дээш оноотой байх мөн түүнчлэн Cambridge First Certificateыг A, B, C дүнтэй дүүргэсэн тохиолдолд шууд сургуулийн шалгалтгүйгээр элсэн орно.

Манай сургуульруу бүртгүүлэхийн тулд сурагч 16 нас хүрсэн байх шаардлагатай.

### **Edmonds Community College ийг хэзээд эхлэх вэ**

Намарын квартал: Есдүгээр сар

Өвөлийн квартал: Нэгдүгээр сар

Хаварын квартал: Дөрөвдүгээр сар

Зуны квартал: Долдугаар сар

Edmonds Community College нь Баруунхойд бүсийн коллеж болон их сургуулийн комиссоор бүрэн эрх олгогдсон ба Вашингтон мужийн коллеж болон техникийн коллежууд хариуцсан ерөнхий хорооны захиргаан доор үйл ажиллагаагаа явуулдаг.

International Student Services

Edmonds Community College

20000 68<sup>th</sup> Avenue West

Lynnwood, Washington 98036, U.S.A

Утас: 425.640.1518

Факс: 425.774.0455

[Iss\\_desk@edcc.edu](mailto:Iss_desk@edcc.edu)

<http://international.edcc.edu>

Edmonds Community College нь арьс өнгө, үндэс угсаа, хүйс, хөгжлийн бэрхшээл, хүйсийн хандлага, нас болон бусад зүйлээр ялгаварлан гадуурхдаггүй гэдгийг цохон тэмдэглэе.

